

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДТАЙ БАЙГУУЛСАН БАТЛАМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2011.03.15

Аймгийн Засаг дарга Ч.Эрдэнэбаатар нь Монгол улсын Ерөнхий сайдтай 10 зүйл заалт бүхий батламж гэрээ байгуулан хэрэгжүүлж ажиллаж байна. Эдгээр заалтуудын хэрэгжилтийг Засгийн газрын 2010 оны 11 дүгээр тогтоолын дагуу хяналт шинжилгээ хийж үзэхэд 100 хувь хэрэгжсэн 6 заалт, 90 хувийн хэрэгжилттэй 4 заалт байна.

Монгол улсын Ерөнхий сайдтай Аймгийн Засаг даргын байгуулсан батламж гэрээний биелэлт нийт дүнгээрээ 96 хувь буюу 4.8 оноотой байгаа нь Ерөнхий сайдын өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай сайн биелүүлсэн гэж үнэлэхээр байна.

Аймгийн эдийн засаг нийгмийн үзүүлэлтүүд сайжирч, 2009-2010 онд төсвийн орлогын өсөлт зарлагын өсөлтөөс давсан, Монгол улсад хамгийн анх удаа “Шударга ёс, ил тод байдлыг эрхэмлэн дээдлэгч аймаг” болох зорилт дэвшүүлэн хэрэгжүүлж байгаа, орон нутагт шаардлагатай мэргэжлээр боловсон хүчин бэлтгэх зорилгоор “Сургалтын төлбөрийг орон нутгийн төсвөөс хариуцан гэрээгээр суралцуулах журам” боловсруулан мөрдөж, 2009-2010 онд 11 хүүхдэд 7,4 сая төгрөг зарцуулсан, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймаг, бүсийн зөвлөгөөнүүд зохион байгуулж, мөрийн хөтөлбөрийнхөө хэрэгжилтийн талаар жил бүр аймгийн ИТХ-д танилцуулж, “Хангалттай сайн хэрэгжсэн” гэсэн үнэлэлт дүгнэлттэй ажилласан байна. Харин гэрээний 1 дэх заалт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад Нийгмийн хамгаалал, хүн ам зүйн бодлогын хүрээнд төрийн захиргааны төв байгууллагаас гаргах ёстой хөтөлбөр, шийдвэрүүд хугацаандаа гараагүйгээс 2 заалт /”Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр” батлагдаж гараагүй, “Гэр бүлийг дэмжих жил” зарлагдаагүй / тасарсан байна. /Хавсралт 2010Re7.doc/

ХЯНАЛТ – ШИНЖИЛГЭЭ , ҮНЭЛГЭЭНИЙ ТАСАГ